



Б. Жадамбаа, Академич,
МУБИС-ийн багш боловсролын зөвлөх

БАГШЛАХУЙН НУУЦЫН НУУЦ

Abstract: In analyzing the ‘teaching action in action’ and its systems, the paper intends to give a more precise description of teaching processes and activities. Today we give more emphasis on teaching action as a process, but we do not mention about teaching action as spontaneity that means to get educated through spontaneous and genuine actions. On the other hand, teaching is not only a process of ‘teaching action in action’ system, but also it is an activity. The ‘action’ of teaching is to ‘teach’, while teaching action in action is ‘to become a teacher. Therefore, the image of good and bad teaching is secret, but it is a spontaneous transformation. The secret of teaching is a spontaneity of how one becomes a teacher and gets educated through his or her spontaneous and genuine actions of teaching. It is rather difficult to measure, but seems possible to approximately determine it. If the person is not a teacher he cannot understand the secret of teaching and its secrets as well. Only a teacher can find the secret law of teaching.

Түлхүүр үг: “үйл, үр”-ийн тогтолцоо, багшлахуйнуудын нэгсэл

Өнөөгийн багшлахуйн талаарх сургаал хэмээсэн бүхнийг нийтээр нь тандан үзэхэд, тэд багшлахуйн жам ёсыг нь тодруулан зүй тогтлыг тодорхойлсон хэдий ч, зүй тогтлыг илрүүлэгч жам ёсны нууц нь түүний мөн чанарын буюу өөрөө болсон ёсонд буйг төдийлөн тодорхой гаргаж өгөөгүй байна. Багшлахуйн мөн чанарын буюу өөрөө болсон ёс бол түүний нууцын нууц. Энэхүү багшлахуйн нууцын нууцыг багш бус болбоос мэдэж үл чаддаг. Зөвхөн багш л мэдэж чаддаг. Багш зүгээр нэг мэдчихгүй. Өөрийн багшлах үйлийн явцдаа тасралтгүй суралцан мэддэг. Тийм ч учраас багшийг хүндэлдэг, дээдэлдэг. Тэрхүү багшийн гүн хүндэтгэлийг үеийн үед хэвээр нь үргэлжүүлж, багшийн нэр хүндийг өндөрт өргөж явах нь үе үеийн багш

нарын үндсэн үүрэг. Энэхүү үндсэн үүргээ нэр төртэй биелүүлэх хийгээд багшлахуйн өөрөө болсон ёсыг журамлан дагасаар түүний нууцын нууцыг улам улам тодруулан баяжуулахад тань дэм тус болох үүднээс дараах хэдэн санааг та бүхэнд толилуулж байна. Уншаад үз. Утгыг нь нягтал. Дахин унш. Учрыг нь ол. Дахиад уншаад үз. Угийг нь эргэцүүлэн нягтал. Тэр бол багшлахуйн нууцын нууц.

Нэгэн зүйл: Багшлахуй нь багш, суралцагчид хамтран хөгжих хамтын үйл болох “үйл үр”-ийн (“үйл зүйл¹”-ийн) тогтолцоо бүхий хоёрдмол шинж төрхт, магадлалт мөн чанарт нэгэн. (1 дүгээр зураг) Хамтын үйл нь агшин тутам багш, суралцагчид бүрд хөгжил бий болгоно. Хамтын үйл бол багшлахуйн “үйл зүйл”-ийн тогтолцооны үйл буюу бүтээх үйл тал. Багш, суралцагчдын хөгжихүй нь багшлахуйн “үйл зүйл”-ийн тогтолцооны зүйл буюу бүтээж байгаа үйл тал. Хамтын үйл талаасаа, багшлахуй нь үйл болох “багшийн үйл”, зүйл болох “суралцагчдын үйл”-ийн нэгсэл нэгэн. Багш, суралцагчдын хөгжихүй талаасаа, багшлахуй нь үйл болох “багшийн хөгжихүй”, зүйл болох “суралцагчдын хөгжихүй”-н нэгсэл нэгэн. Багшийн хөгжил суралцагчид хөгжил авч ирнэ. Эсрэгээрээ суралцагчдын хөгжил багшид хөгжил бий болгоно.

Нэгэн зүйл: Багшлахуйн тухайн агшинд багшид ба суралцагчдад бий болсон хөгжлийг нэгэн зэрэг тодорхойлж болдоггүй. Мөн багшийн ба суралцагчдын үйлийг ч нэгэн зэрэг тодорхойлж болдоггүй. Аль нэг нь тодорхой болохоор нөгөө нь тодорхойгүй болдог. Өөрөөр хэлбэл, шалтгаалцлын зарчим биелдэггүй. Энэ бол багшлахуйн “тодорхойгүйн зарчим”. Багшлахуйн хувьд тодорхой байдаг

1 *Уг ажилд бүтээж байгаа үйл буюу үрийг энэ ажилд “зүйл” -ээр, хийх үйлийг үйл гэж тус тус ойлгон ярьж бичих болно.*

нэгэн бол түүний хоёрдмол шинж төрхийг эвсүүлэгч, нэгсүүлэгч үнэн магад чанар болох “үйл зүйл”. Үнэн магад чанар болох “үйл зүйл” бол багшлахуйн уг дүрсийг буюу дүрс байдлыг илэрхийлэгч. Багшлахуйн уг дүрс, дүрс байдал нь үнэн магад чанар бүхий зүйлс. Иймд башлахуйн сайн ба муу нь харьцангуй ойлголт.

Нэгэн зүйл: Багшлахуй, түүний бүтэц тогтолцооны (Зураг-1), “үйл зүйл”-ийн (“үйл үр”-ийн) тогтолцоо болох багшлахуй нь “орон -цаг -тоо- чанар” -ын нэгсэл нэгэн төдийгүй ерөнхий бодитой талаасаа бол “багш суралцахуй”, ерөнхий хийсвэр талаасаа бол “суралцагчид багшлахуй”, тусгай бодитой талаасаа бол “багш багшлахуй”, тусгай хийсвэр талаасаа бол “суралцагчид суралцахуй” гэж тус тус харагдаж байна (хүснэгт-1). Багшлахуй нь орон - цаг буюу мөн чанар талаасаа үйл болох суралцагчид багшлахуй, үр болох багш суралцахуйн, харин тоо - чанар буюу үзэгдэл талаасаа үйл болох багш багшлахуй, үр болох суралцагчид суралцахуйн нэгдэц болох “үйл үр”-ийн тогтолцоонууд байна. Эдгээр “үйл үр”-ийн тогтолцоонуудын “үр”-үүд нь харгалзан “багш суралцахуй”, “суралцагчид суралцахуй. Багш суралцахуйг бүтээх үйл нь багшийн үйл, бүтэж байгаа үйл нь багш хөгжихүй. Суралцагчид суралцахуйг бүтээх үйл нь суралцагчдын үйл, бүтэж байгаа үйл нь суралцагчдын хөгжихүй. Тэгэхээр багшлахуйг багш, суралцагчид хамтдаа хамтран “үйлийн явцдаа суралцан хөгжихүйд суралцахуй” гэж хэлж болохоор байна. Багшлахуйн зорилго бол суралцагчдыг “үйлийн явцдаа суралцан

хөгжихүйд, өөрөөр хэлбэл, үйлийн судалгаанд сургах”.

Нэгэн зүйл: Ерөнхий ба тусгай бодитой харьцаан дахь багшлахуйн “үйл үр”-ийн тогтолцооны үйл буюу бүтээх (төрүүлэх) үйл нь “багш суралцахуй”, үр буюу бүтээж байгаа үйл (зүйл) нь “багш багшлахуй” байна. Багш суралцахуй бол багш багшлахуйг төрүүлэгч. Багшлахуй бол багш суралцахуйн үр буюу зогсонги тал. Багш суралцахуй бол цаг тул тэр тасралтгүй шинж төрхтэй. Тиймийн учир багш үйлийн явцдаа тасралтгүй суралцана. Тэрхүү үйлийн явцдаа суралцахуйн хөгжихүйн агшнуудын тасралтгүй цувраа багш багшлахуйг бүрдүүлнэ.

Нэгэн зүйл: Багшлахуй бол орон- цагаа өвөрлөсөн нэгэн. Цагаа өвөрлөсөн учраас багшлахуй нь цагийн зүүний дагуу буюу ирээдүй рүүгээ, дотогшоогоо эргэлт буцалтгүйгээр, үргэлжид мөнх урсаж хуйлран (шугаман бус хаос маягтайгаар) өөрөө болсон ёсны үйл тал. Аяндаа цэгцрэн нэгсэж нэг болохуй нь багшлахуйн өөрөө болсон ёсны үр тал. Энэ нь “үйл үр” бол багшлахуйн өөрөө болсон ёсны нууц хууль гэсэн үг. Багшлахуйн үйл үрийн эргэлт буцалтгүйгээр үргэлжид мөнх урсаж хуйлран өөрчлөгдөхүйн агшнуудын тасралтгүй цувраа хугацааг, тэдгээр “одоо” цагуудад дахь аяндаа цэгцрэн нэгсэж нэг болохуй буюу тухайн багшлахуй үргэлжилсэн цувраа багшлахуйг тус тус бүтээнэ. Энэ бол багшлахуйн өөрөө болсон ёс.



Зураг-1. Багшлахуй, түүний “Үйл Зүйл”-ийн тогтолцоо

Нэгэн зүйл : Багшлахуйн улирч хувьсах нууц төлөвийн эргэлт буцалтгүй чанар, үргэлжид мөнх урсаж хуйлхан өөрчлөгдөхүй, аяндаа цэгцрэн нэгсэж нэг болохуй дөрөв бол түүний өөрөө болсон ёсны нууц хуулийн нууцууд. Эргэлт буцалтгүй чанарынхаа ачаар багшлахуй эмх цэгц байнга дээшилж байдаг. Энэ бол багшлахуйн эмх цэгц (“энтропи”) өсөх хууль. Өөрөөр хэлбэл, “эрдмийн дээд эв, эрхмийн дээд” эх хэмээх хууль.

Нэгэн зүйл: Суралцагчид бол багшийн багш. Тэд багшид багшилна, бас багшийг хөгжүүлнэ. Багш суралцагчдаасаа сурна, бас тэдний хийгээд өөрийнхөө үйлийн ачаар хөгжинө. Багш хөгжихүй нь түүний үйлийн явцдаа байнга суралцан хөгждөг болохуй хийгээд болсон байдал. Багш та үйлийн явцдаа үргэлжид суралцан хөгжсөөр гавьяаны амралтад гарах тэр агшиндаа сайн багш болдог. Өөрөө үйлийн явцдаа суралцаж хөгжиж сураагүй

багш суралцагчдыг үйлийн явцдаа суралцаж хөгжихүйд сургаж чаддаггүй. Багш суралцагчдад багшилна. Багшийн үйл суралцагчдыг хөгжүүлнэ. Суралцагчид багшийн болон өөрсдийн үйлийн ачаар хөгжинө. Суралцагчдын хөгжихүй нь тэдний үйлийн явцдаа суралцаж хөгждөг болохуй, болсон байдал.

Нэгэн зүйл: Багшлахуй нь тухайн багшлахуйнуудын нэгсэл нэгэн. Тэр бол оронгүй, цаггүй. Харин түүний дүр болох тухайн багшлахуй бол орон-цагтайгаа төрдөг. Тэр өөрийнхөө орон-цагт бий болж, орон-цагтаа оршиж, орон-цагтаа өндөрлөдөг. Тухайн багшлахуй бүрийн дүрс байдал өөр өөрийнхөө зүйг дагаж бүтэж эвдэрч байдаг.


Нэгэн зүйл: Багшлахуй, түүний “үйл зүйл”-ийн тогтолцооны (Зураг-1) -ийн дээд хагас хавтгай нь түүний багшийн үйлтэй, доод хагас хавтгай нь суралцагчдын үйлтэй тус тус холбоотой зүйл.

Орон-цаг-тоочанар		Харах тал	Харагдах байдал буюу томъёолол	Зорилго	“үйл-зүйл”-ийн тогтолцоо	
					Үйл -хийх үйл	Зүйл-бүтэх үйл
Мөн чанар	Орон-цаг	Ерөнхий бодитой буюу цагийн харьцаа тал	Багш суралцахуй	Багшлах үйлийн явцдаа тасралтгүй суралцаж хөгждөг болохуй	Багшийн үйл	Багш хөгжихүй (багшийн хөгжил)
		Ерөнхий хийсвэр буюу орны харьцаа тал	Суралцагчид багшлахуй	Багшийг суралцахуй сургахуй	Суралцагчдын үйл	
Үзэгдэл	Тоо-чанар	Тусгай бодитой буюу тооны харьцаа тал	Багш багшлахуй	Суралцагчид үйлийн явцдаа суралцаж хөгждөг болохуй	Багшийн үйл	Суралцагчид хөгжихүй (Суралцагчдын хөгжил)
		Тусгай бодитой буюу чанарын харьцаа тал	Суралцагчид суралцахуй		Суралцагчдын үйл	

Хүснэгт-1. Багшлахуйн бүрдүүлбэрүүдийн “үйл зүйл”-ийн тогтолцоо

Тэр хоёр гэрэл сүүдэр мэт бие биенээ байнга дагаж явдаг зүйлс. Багшийн үйлд суралцагчдын үйл тархсан байдаг бол, суралцагчдын үйлд багшийн үйл хурсан байдаг. Суралцагчдын үйл тархсан багшийн үйлийн “үйл зүйл”-ийн тогтолцоо нь нэг талаас, үйл болох багшийн сурган хүмүүжүүлэхүй, зүйл болох багшийн сурч хүмүүншихүйн, нөгөө талаас, үйл болох

багшийн багшлахуй, зүйл болох багшийн суралцахуй нэгсэл нэгэн хэмээн харагдаж байна (Зураг-2). Багшийн сурган хүмүүжүүлэхүй бол суралцагчдыг үйлийн явцдаа суралцаж хөгждөг буюу суралцаж хүмүүншдэг болгохуй. Багшийн сурч хүмүүншихүй бол багш үйлийн явцдаа суралцаж хөгждөг буюу сурч хүмүүншдэг болохуй.



Зураг-2. Багшийн үйлийн бүтэц тогтолцоо

Багшийн үйлийн бүтэц тогтолцооны (Зураг-2) -оос, багшлахуй ба сурган хүмүүжүүлэхүй бол багшийн үйлийн илрэл. Суралцахуй ба сурч хүмүүншихүй бол багшийн үйлийн, багшлахуйн мөн чанар. Багшлахуй хийгээд суралцахуй нь сурч хүмүүншихүй ба сурган хүмүүжүүлэхүйн нэгдэц. Багшлахуйн илрэл нь сурган хүмүүжүүлэхүй. Багшлахуйн мөн чанар тал нь сурч хүмүүншихүй. Сурган хүмүүжүүлэхүй нь сурч хүмүүншихүйн илрэл.

Мөн чанар талаасаа бол, суралцахуй хийгээд багшлахуй нь харилцан үйл, үр болсон зүйлс. Иймийн учир, багш бүр энэ хоёрыг зэрэг л эрхлэх хэрэгтэй болдог. Мөхөс миний ерөнхий шинжилгээнээс үзэхэд, өнөөгийн багш нарын олонх багшлахуйг эрхлэн, суралцахуйг эрхлэх нь маш цөөн байна. Суралцахуй нь багшлахуйг бүтээх үйл. Багшлахуй бол суралцахуйн бүтээж байгаа үйл буюу үр. Суралцахуй хэдий их сайн болох аваас багшлахуй мөн төдий их сайн болох болно. Суралцахуйг эрхлэвээс багшлахуйг эрхлэх нь түүний дотор оршин байдаг. Учир нь, суралцахуйд багшлахуй тархсан байдаг. Харин багшлахуйд суралцахуй хурсан байдаг. Суралцахуйг эрхлэх нь багшлахуйг эрхлэхүйн нэгэн зүйл. Түүний туйл биш. Суралцаж байж л багш нар багшлахуйн өөрөө болсон ёсыг журамлан дагадаг болно. Багшлах эрдмийг эзэмшинэ. Багшлах эрдэм бол багшлахуйн өөрөө болсон ёсыг журамлан дагахуй. Бас багшийн ном эрдэм гэнэ. Хэрвээ багшлахуйг эрхлэхгүй бол журамлан дагах ёсыг олж мэдэхгүй бөгөөд суралцах оюун төрөгдөхгүй болно. Багшлахуй нь суралцахуйг эрхлэхүйн нэгэн зүйл, мөн түүний туйл биш. Багшлахуйг эрхлээд суралцахуйг эрхлэхгүй бол багш нэрээр цалин авдаг атлаа багш нэрийг гутаагч нэгэн болно. Ийм л учраас багш бүр суралцахуй хийгээд багшлахуйг зэрэг эрхлэхийг хичээвэл зохино. Энэ хоёрыг зэрэг эрхлэхүй бол багшийн үйлийн явцдаа байнга суралцаж хөгжихүй буюу багшийн үйлийн судалгаа.

Нэгэн зүйл: Багшлахуй нь өөрөө боловсорно. Багш бүрийн сайн муу явдал нь адилгүй тул багшлахуйн “үйл үр” мөнхүү адилгүйгээр боловсорно. “Үйл үр”-ийн нь сайн муу байдал хариулан ээлжилж, улирч хувирах нь багшлахуйн өөрөө боловсрох ёс. Багшлахуй өөрөө болсон зүйгээ дагаж өөрөө боловсорно. Иймийн учир өмнө “үйл үр” -ийг багшлахуйн сайн муугийн дүрс буюу дүрс байдал гэсэн билээ. Номын цагаан буян дэлгэрэх болтугай

ДҮГНЭЛТ

Багшлахуйг “үйл үйл”-ийн гүн ухааны үүднээс шинжин, түүнийгээ бусад судлаачдын дэвшүүлсэн санаа бодлуудтай харьцуулсанаахуа үндсэн дээр дараах дүгнэлтийг хийж байна:

- Багшлахуй нь өөрөө болсон “үйл үйл”-ийн нууц хууль бүхий нэгэн.

АШИГЛАСАН МАТЕРИАЛ

- Базаррагчаа, М. (1995). *Монгол үгийн гарлыг мөшгөх нь*. V. Улаанбаатар
- Болд, Л. (2008). *Монгол хэлний дэлгэрэнгүй тайлбар толь*. IV боть, 2300 дугаар тал. Улаанбаатар
- Баярсайхан, Б. (2009). *Монгол хэлний хураануй тайлбар, толь*. 742 дугаар тал. Улаанбаатар
- Дэмчигдорж, Ч. (1993). *Эрдэнэт толь хэмээх шастир оришвой*. 85 дугаар тал. Улаанбаатар
- Жадамбаа, Б. ба бусад. (2015). *Тогтворшилтой хөгжлийн боловсролын онол, аргазүйн зарим асуудал, 54- 64 дүгээр тал*. Улаанбаатар
- Жадамбаа, Б. (2010). *Үйлийн явцдаа суралцаж хүмүүншихүй, УБ.*, 10 дугаар тал.
- Крейдлин, Г.Е., Кронгуз, М.А. (2004). *Семиатика или Азбука общения, Учебное пособие, “Флинта Наука”, М., стр., 182- 205.*
- Лувсанвандан, Ш. (1999). *Орчин цагийн монгол хэлний бүтэц, 146 дугаар тал*. Улаанбаатар